

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮД, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“26.5.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 2024 оны гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:


1.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайланг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.”

2.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд үүрэг болгов:

2.1.“Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилтын хүрээнд салбарын үр дүнг шалгуур үзүүлэлтийн хамт оновчтой тодорхойлж, 2025 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэрийг тооцох, зорилтот түвшнийг тодорхойлох аргачлалыг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт;

2.2.“Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

2.3.Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг урт хугацааны бодлогын баримт бичиг, холбогдох зорилттой уялдуулж, зорилт бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг цахим системээр боловсруулах, батлуулах, гүйцэтгэлийг тайлагнах, түүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нэгдсэн тогтолцоог бий болгох санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр нарт.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР